

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2017.02.01

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 01 дүгээр сард 2 удаа хуралдаж 10 гаруй асуудал хэлэлцэн 22 тогтоолыг батлан гаргаж, хурлын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа.

Тухайлбал:

-2017 онд аймгийн хэмжээнд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, байршил, хэмжээг сум тус бүрээр, аймгийн нутаг дэвсгэрээс 2017 онд ойгоос бэлтгэх модны төрлөөр тогтоосон дээд хязгаарыг сум бүрээр, огтлолын төрлөөр тогтоосон дээд хязгаарыг сум бүрээр, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойн санд явуулах цэвэрлэгээний огтлолын талбай, бэлтгэх модны дээд хязгаарыг, “Ойн цэвэрлэгээ” хөтөлбөрийн хүрээнд бэлтгэх модны дээд хязгаарыг сум бүрээр тус тус тогтоож, Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгээр аймгийн 2015 оны орон нутгийн өмчийн эргэлтийн хөрөнгийг 19 661 551 532.83 /арван есөн тэрбум зургаан зуун жаран нэгэн сая таван зуун тавин нэгэн мянга таван зуун гучин хоёр төгрөг наян гурван мөнгө/ төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дүнг 225 778 224 408.48 /хоёр зуун хорин таван тэрбум долоон зуун далан найман сая хоёр зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун найман төгрөг дөчин найман мөнгө/ төгрөгөөр баталж, аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналыг үндэслэн зарим байгууллагын балансад бүртгэлтэй тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийг балансаас балансад шилжүүлэх, олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид албан ажилд ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа “Сэлэнгэ барилга захиалагч” ОНӨААТҮГ-ын балансад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, “Гавшгай-Ус” ХХК-ий балансад бүртгэлтэй тоног төхөөрөмж, Хөдөө аж ахуйн газрын балансад бүртгэлтэй тавилга эд хогшил, тоног төхөөрөмж зэрэг хөрөнгүүдийг актлах, ашиглалтгүй байгаа хуучин Тээврийн удирдах газар байрлаж байсан 2002 онд аж ахуйн аргаар барьж ашиглалтанд оруулсан 12*6 хэмжээтэй 2 давхар модон барилгыг актлах, мөн “Гавшгай-Ус” ХХК-ий балансад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг дуудлага худалдаагаар худалдах тухай асуудлыг шийдвэрлэсэн.

-Нутгийн захиргаа, боловсрол, төмөр замын тээврийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 3, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 3, Алтан гадас одонгоор 15, Цэргийн хүндэт медалиар 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 4 хүнийг шагнуулахаар уламжилсан.

-Санхүүгийн хяналт аудитын албаны төлөвлөгөөг батлах, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчдын хийсэн аудитын үйл ажиллагааны тайланг хэлэлцэж үнэлэлт дүгнэлт өгч ажиллах үүрэг бүхий дотоод аудитын хороог аймгийн Засаг даргын дэргэд байгуулж, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай “Урсгал-Ус”, “Цант Орхон”, “Гавшгай-Ус” компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг өөрчлөн баталсан.

-Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг Сэлэнгэ аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний 2015-2018 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц байдал, үр дүнгийн тухай аймгийн Засаг дарга, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн аймгийн салбар хорооны даргын мэдээллийг хэлэлцээд уг төлөвлөгөөний 2015-2016 оны хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэлээ.

-Сэлэнгэ аймгийн хэмжээнд гарч байгаа сүрьеэ бэлгийн замаар дамжих халдварын өвчлөл, тархалтын өнөөгийн байдал, түүнийг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын талаарх аймгийн Эрүүл мэндийн газрын даргын сонсголыг

хэлэлцээд дээрх өвчлөлийн тархалтыг бууруулахад аймаг, сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлж тодорхой үр нөлөөтэй ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзэн албан даалгавар өглөө.

-”Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн байдлын талаар аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын мэдээллийг сонсоод аймгийн Засаг даргад, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр төсөл, хөтөлбөр, ажил үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, төрийн чиг үүргийг гүйцэтгэгч байгууллага нэгжийн дарга, захирал нарт, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргад албан даалгавар өгөгдлөө.

-Сум орон нутаг иргэдээс ирүүлсэн саналыг үндэслэн Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Мөнх амин үг баптист” сүм, Сайхан суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Хөтөл амийн үг”, “Хайрын жим” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

“Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг энэ сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулж, 2017 оны бодлого зорилт, цаашид анхаарч ажиллах талаар үүрэг чиглэл өгч, аймгийн Засаг даргаас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг дарга, ОНӨААТҮГ, сумдын ойн ангийн дарга, нийгмийн салбарын үйлчилгээний байгууллагуудын дарга, захирал эрхлэгч нартай үр дүнгийн болон хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол нийт 112 шийдвэрийн 138 шийдвэрийн хэрэгжилтийг 94,27 хувийн гүйцэтгэлтэй, 2016 онд аймгийн хэмжээнд нийт 25395 өргөдөл гомдол ирүүлсний 24191 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, шийдвэрлэлт 94,9 хувийн гүйцэтгэлтэйгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн тайлагнасан. Мөн Монгол Улсын Төрийн албаны салбар зөвлөлд төрийн албан хаагчийн 2016 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайланг боловсруулж хугацаанд нь хүргүүлсэн бөгөөд аймгийн хэмжээнд 203 байгууллагын 5991 төрийн албан хаагч бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланд бүртгэгдсэн.

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдаж мөрдөж эхэлсний 25 жилийн ой тэмдэглэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн агуулга, ач холбогдлыг сумдад сурталчлах, нас барсан депутатуудын ар гэрийнхэнд хүндэтгэл үзүүлэх, Алтанбулаг сумын төвд байрлах аймгийн Музейд “Үндсэн хуулийн булан”-г нээж хүүхэд, залуучууд, багш, сурагчдыг танилцуулах ажлыг тогтмол зохион байгуулах ажлыг эхлүүлсэн. Мөн Үндсэн хуулийн өдөрт зориулсан Шатрын тэмцээнийг аймгийн хэмжээнд амжилттай зохион явуулж, эрэгтэй 257, эмэгтэй 89 нийтдээ 346 тамирчид оюун ухаанаа сорин өрсөлдөж, С.Сундуй, С.Хишиг-Очир, А.Гэрэлтогтох нарын тамирчид тэргүүн байруудад шалгарсан.

“Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц” төслийг аймгийн төв Сүхбаатар суманд хэрэгжүүлэх санал ажил хэрэг болж, аймгийн Засаг даргын захирамжаар төсөл хэрэгжүүлэх нэгжийг шаардлагатай мэдээлэл, тооцоо судалгаагаар хангах ажлын хэсэг томилогдон, төслийн бэлтгэл ажлыг эхлүүлсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас томилогдсон ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Алтанбулаг боомтыг орчин үеийн боомтын түвшинд хөгжүүлэхэд шаардагдах асуудал, Сүхбаатар хотод “Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц”-ийн төслийг хэрэгжүүлэх асуудлаар санал солилцсон. Мөн Гадаад харилцааны дэд сайд Б.Батцэцэгээр ахлуулсан ажлын хэсэг Алтанбулаг, Хиагтын боомтын бодит нөхцөл байдал, тулгараад байгаа асуудлуудтай газар дээр нь танилцаж асуудлыг Засгийн газар, яамны түвшинд хэрхэн шийдвэрлэх, асуудлыг хэрхэн сайжруулах талаар хил, хяналтын байгууллагуудтай уулзаж харилцан ярилцсан.

Аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг ОХУ-ын Саха /Якутия/ Улсад 1-р сарын 11-13-ны өдрүүдэд ажиллаж, тус улсын Засгийн газрын тэргүүн, ерөнхийлөгч Е.А.Борисов, Засгийн газрын дарга, Ерөнхий сайд Е.А.Чекин болон Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын яам, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, М.К.Аммосовын нэрэмжит Хойд Дорнын Холбооны Их Сургууль, “Сахабулт” нээлттэй хувьцаат нийгэмлэг, төрийн өмчит улсын үйлдвэрийн газар, Саха-Монголын нийгэмлэг, “Дети Азии” буюу “Азийн хүүхдүүд” олон улсын спортын их наадмыг зохион байгуулах хороо зэрэг байгууллагуудын удирдлагуудтай уулзан санал солилцож, Саха Улсын боловсрол, соёл, спортын салбартай хамтарч ажиллах, хүүхэд залуучуудын хөгжилд чиглэгдсэн төслүүдийг хэрэгжүүлэх, Саха /Якутия/ Улсын үнэт эдлэл болон бусад үйлдвэрийн салбаруудыг Сэлэнгэ аймагт нээх, Монгол Улс, Сэлэнгэ аймгаас ноос ноолууран болон мах, махан бүтээгдэхүүнийг Саха Улсад нийлүүлэх хамтарсан үйлдвэр байгуулах, Хоёр улсын соёл, эдийн засгийн өдрүүдийг харилцан зохион байгуулах, Хойд Дорнын Холбооны Их сургуульд оюутан суралцуулах асуудлуудыг судалж, хамтын ажиллагааны гэрээндээ тусгахаар урьдчилсан байдлаар тохиролцож протоколд гарын үсэг зурсан. Мөн өнгөрсөн 12-р сард Монгол улсын Ерөнхий сайдын Япон улсад айлчлах ажлын хэсэгт тус аймгийн Засаг дарга ажиллаж, Япон улсын Шизуока мужтай ХАА-н салбарт хамтран ажиллах санамж бичгийг байгуулсны дагуу энэ оны 1-р сарын 09-13-ны өдрүүдэд аймгийн ажлын хэсэг Япон улсын Шизуока мужид ажиллаж, “Газар тариалангийн салбарт хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан бөгөөд санамж бичигт мэргэжлийн боловсон хүчин солилцох, гурвалжин будаа тариалах, хураан авсан ургацаа Япон улсад экспортонд гаргах асуудал тусгагдсан.

Аймгийн “Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл”-ийн нэгдсэн зөвлөгөөн болж, зөвлөгөөний үеэр аймгийн Засаг даргын “Аян зохион байгуулах тухай” 2017 оны А/19 захирамжийг гарган хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн гишүүд, сумдад хүргүүлсэн.

Онцгой байдлын талаар:

2017 оны 1 дүгээр сард 8 удаагийн объектын гал түймэр гарсанаас 1 гал түймэр мэдээллээр ирж, гал түймрийн улмаас нийт 124.535.500 төгрөгийн хохирол учирсан.

Гал түймэр унтраах, аврах ангиуд нийт 7 удаагийн объектын гал түймрийн дуудлагаар ажиллаж, 7 гал түймрийг 28 тонн ус, 282.75 л шатахуун зарцуулан унтрааж, гал түймрийн аюулаас аж ахуйн нэгж, байгууллагын 77 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалсан.

Гал түймрийн нөхцөл байдлыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:

д/д	Гал түймрийн төрөл	2016 оны 1 дүгээр сар	2017 оны 1 дүгээр сар	Өссөн, буурсан
1	Объектын	12	8	-33.3

Аймгийн Онцгой байдлын газар, ДЗМОУБ Сэлэнгэ ОНХХ-тэй хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу "Үер", "Ой, хээрийн түймэр", "Мөс цөмрөх", "Газар хөдлөлт", "Хийн түлш", "Гал түймэр", "Зуд", "Ахуйн осол", "Хүн, малын гоц халдварт өвчин", "Аянга", "Хүчтэй цасан болон шороон шуурга" зэрэг 11 төрлийн хэвлэмэл хуудас болон сэрэмжлүүлэг тараах материалыг нийт 14000 ширхэгийг хэвлүүлэн хүлээн авч урьдчилан сэргийлэх ажилд хэрэглэж байна.

Аймгийн Онцгой комисс, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар хамтран Зүүнбүрэн, Түшиг, Хушаат, Хүдэр, Ерөө, Жавхлант, Баруунбүрэн суманд өвөлжилт хүндэрсэн үед үзүүлэх явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ “Халуун сэтгэл 2017” аяныг зохион байгуулсан. Аяны хүрээнд дээрх сумдын сумын төвөөс алслагдсан малчин, мал бүхий 661 өрхийн 1654 иргэнд эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүллээ.

Голын мөсний зузааны хэмжилтийг 2 удаа Эрэн хайх аврах ангийн биебүрэлдэхүүний хамтаар Орхон-Сэлэнгийн бэлчир, Орхон голын нүхэн гүүр орчмын газруудад хийж иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, багийн Засаг дарга нараар дамжуулан тогтмол мэдээллэн голын мөсөн дээгүүр тээвэр хийхгүй байх талаар сэрэмжлүүлэг зөвлөмжийг тогтмол хүргэж мөс цөмөрч болзошгүй эрсдэл бүхий газруудад сэрэмжлүүлэг самбар байршууллаа.

Мэргэжлийн хяналтын ажил үйлчилгээний талаар:

Тус аймгийн Хүдэр суманд 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн УМЭАЦТЛ-ийн 17-106, 17-17-107 тоот шинжилгээний хариугаар малын гоц халдварт цэцэг өвчин мөн болох нь батлагдсан.Сумын Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 04 тоот захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоон ажиллаж, нийт 9 өрхийн 1657 малыг зориудын устгалд оруулаад байна.Аймгийн Засаг даргын 2017 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн “Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тухай” захирамж гарч Хүдэр, Алтанбулаг, Ерөө, Баянгол, Жавхлант, Хушаат сумдын нийт хонинд цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинийг хийсэн. Өнөөдрийн байдлаар Хүдэр 12175, Алтанбулаг 22200, Ерөө 32800, Жавхлант 46640, Баянгол 62800, Хушаат сумын 15000 –н толгой хонь, нийт 192745 толгой хонийг бүрэн вакцинжуулж дуусаад байна. Малчдаас тарилгын талаар ямар нэгэн гомдол санал гараагүй байна.

2017 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр архи согтууруулах ундаа хэрэглэсний улмаас хүний амь нас эрсэдсэн тохиолдол гарсан тухай мэдээллийн дагуу Аймгийн Засаг даргын захирамж гарч энэ сарын 17-19-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдахыг хориглосон. Үүнтэй холбогдуулан аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар хамтран гэнэтийн байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 92 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, 17 сум, 6 тосгоны 296 объектэд хийв. Шалгалтын явцад Мөнхжин Од ХХК-ийн үйлдвэрлэсэн “Найрсаг” нэрийн 0.5л-ийн савлагаатай 61 шил архийг битүүмжлэн зохих журмын дагуу дээж авч аймгийн МХГ-ын дэргэдэх итгэмжлэгдсэн лабораторит шинжлүүлэхээр өгсөн ба шинжилгээний эцсийн дүн гараагүй байна. /Шалгалт үргэлжилж байна/

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Мандал, Алтанбулаг, Баянгол, Түшиг, Хүдэр, Сүхбаатар сумын 11 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний 9 хүнсний дэлгүүр, 1 баар, 1 үсчний газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, Сүхбаатар, Сайхан, Шаамар сумын 7 аж ахуйн нэгж иргэний 4 нэрийн 10 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулж, Сүхбаатар сумын “Өгөөмөр Үжээд” ХХК-ний үйлдвэрлэж буй бууз баншны хаяг шошгыг стандартад нийцүүлэн шинэчлэх арга зүйн заавар өгч, Сайхан сумын “Жавхлант групп” ХХК-ий “Гацуурт” гурилын үйлдвэрийн буудайн гурилыг тохирлын баталгаажуулалтанд хамруулж гэрчилгээ олгосон.

Стандартын салбар сангаас 14 аж ахуй нэгж, иргэний хүсэлтийн дагуу 10 нэрийн 16 стандартын захиалгыг авч, 9 аж ахуйн нэгж, байгууллага иргэнийг 6 нэрийн 11 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүллээ.

Механик хэмжлийн ээлжит бус баталгаажуулалтаар 13 электрон жин, Сайхан сумын “МТС” ХХК-ний ШТС-д шинээр дизель түлшний шингэн хэмжигч суурилуулсныг, Сүхбаатар сумын “Сод монгол” ШТС-д шинээр үйл ажиллагаа эхлэх гэж байгаатай холбогдуулан түгээгүүрийн баталгаажуулалтыг тус тус хийж, Сүхбаатар сумын худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа 53 жин, айл өрх, аж, ахуй нэгж, байгууллагын төлбөрийн тооцоонд ашиглагдаж байгаа 1 фазын 20 ширхэг цахилгаан тоолуур баталгаажуулсан.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Монгол Улсын Сангийн яамнаас зохион байгуулсан 2016 оны Төсвийн Ерөнхийлөн захирагчийн жилийн эцсийн тайлангийн нэгтгэлтэй холбоотой сургалтанд холбогдох мэргэжилтнүүд хамрагдаж, 2017 оны төсвийн жил эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын удирдлага мэдээллийн системийн шинэчлэлтэй

уялдуулан төсвийн Fiscal програмд сумын болон аймгийн төсвийн байгууллага, тусгай зориулалтын шилжүүлгийн нийт 210 байгууллагын төсвийн сар улирлын хуваарийг бүрэн шивж оруулан, зарцуулалтын эрхийн баталгааг Сангийн ямаар бүрэн татуулан, төрийн сангийн хэвийн ажиллагааг хангаж ажиллалаа. Тайлант сард аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 374 баримтаар 1 592 611 780 төгрөгийн гүйлгээ хийж, төсвийн байгууллагуудын санхүүжилтийг олгосон.

Аймгийн нийгэм, эдийн засгийн 2016 оны жилийн эцсийн танилцуулгыг боловсруулан гаргаж, аймгийн удирдлагуудад, 17 сум, 24 хэлтэс агентлагуудад хүргүүлж, танилцуулгыг selenge.nso.mn цахим хуудсаар цахим хэлбэрээр мэдээлсэн.

2016 оны жилийн эцсийн татварын орлогын гүйцэтгэлийг сумдын татварын байцаагч болон, Санхүүгийн албатай тулган баталгаажуулж, 2016 оны аж ахуйн нэгж байгууллагуудын татварын өглөг, авлагын тооцоог нийлж, татварын өглөг барагдуулах арга хэмжээ авч байна. Мөн татварын хөнгөлөлт эдлэх хүсэлт гаргасан иргэдийн материалыг хүлээн байгаа бөгөөд, нийт 920 иргэнд хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх гарын авлагаар хангасан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Орон нутгийн төсвийн нийт орлого	17,030,440.7	18,610,004.5	109,3
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	12,637,796.8	12,798,910.0	101,3
2	Орон нутгийн төсвийн нийт зарлага	71,644,329.1	69,144,391.9	96,5
	Үүнээс: Аймгийн төсвийн зарлагын дүн	16,084,679.7	15,432,968.2	95,6
	-Аймгийн ОНХСангийн зарцуулалт	2,315,861.1	2,222,589.0	96,0
	-Аймгийн авто замын хөрөнгө оруулалт	984,371.1	558,382.4	81,6
	-Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	955,579.4	7,8,428.4	77,3
3	Улсын төсвөөс олгосон ОНХСангийн орлогын шилжүүлэг	4,887,340.1	4,887,340.1	100,0
4	Улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг	4,059,657.8	4,059,657.8	100,0
5	Улсын төсвөөс олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	43,171,622.7	43,171,622.7	100,0
	- Ерөнхий боловсролын сургууль	22,141,723.4	22,141,723.4	100,0
	- Хүүхдийн цэцэрлэг	11,175,773.4	11,175,773.4	100,0
	-Эрүүл мэнд, спортын байгууллага	6,358,036.7	6,358,036.7	100,0
	-Соёлын байгууллагуудын	2,981,245.3	2,981,245.3	100,0
	-Газрын харилцаа кадастрын алба	228,261.7	228,261.7	100,0
	-Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	286,282.2	286,282.2	100,0
6	Төсвийн байгууллагуудад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	43,171,622.7	43,171,622.7	100,0
	-Ерөнхий боловсролын сургууль	22,177,262.4	22,177,262.4	100,0
	-Хүүхдийн цэцэрлэг	11,096,740.8	11,096,740.8	100,0
	-Эрүүл мэнд	4,986,312.5	4,986,312.5	100,0
	-Өрхийн эмнэлэг	550,746.5	550,746.5	100,0
	-Спортын байгууллагуудын	820,977.7	820,977.7	100,0
	-Соёлын байгууллагуудын	3,024,738.9	3,024,738.9	100,0
	-Газрын харилцаа кадастрын алба	228,561.7	228,561.7	100,0
-Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс	286,282.2	286,282.2	100,0	
7	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	3,932,066.7	3,932,066.7	100,0

8	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,663,769.9	2,622,549.2	98,5
9	Аймгийн нийт ангилагдаагүй зардал	955,283.6	818,923.3	85,7
10	Үүнээс: Аймгийн Засаг даргын нөөц	418,045.2	416,323.8	99,6
11	Тусгай сангуудын зарлага	5,468,944.6	1,027,897.6	18,8

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2016 XI- сар	2016 XII- сар	<u>2016-XII</u> <u>2016-XI</u> /төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1200	1200	
	Талх /орон нутгийн, ш/	1100	1100	
	Нарийн боов /кг/	2000	1900	-100
	Будаа /кг/	2300	2400	+100
	Элсэн чихэр /кг/	2100	2300	+100
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	4500	4500	
	Үхрийн мах /кг/	5500	5500	
	Адууны мах /кг/	4300	4500	+200
	Ямааны мах /кг/	3000	3000	
	Дотор мах, цувдай /цусгүй/	3500	3000	-500
	Хиам /чанасан, кг/	9000	9800	+800
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1100	1400	+400
	Сүү / савласан, л/	2500	2500	
	Тараг /задгай, л/	1500	1500	
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	12000	11000	-1000
	Айраг /л/	3500	3500	
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4000	4000	
	Өндөг /ш/	280	300	+20
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	3500	3400	+100
	Өөхөн тос /кг/	1500	1500	
	Шар тос /кг/	10000	10000	
	Масло /задгай, кг/	5000	5000	
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	800	
	Лууван /кг/	6000	600	
	Манжин /кг/	8000	800	
	Байцаа /кг/	1000	1000	
	Сонгино /кг/	1500	1500	
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3200	3200	
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2000	2000	
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1450	1450	
	Бензин А - 92	1530	1530	
	Дизелийн түлш	1640	1640	

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

Захиргааны ерөнхий хуулийг сурталчлах, хэрэглэх талаарх сургалтыг аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн ажилтнуудад зохион байгууж, Ерөө суманд Захиргааны ерөнхий хууль, Хүний эрхийн тухай ойлголт, Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь, ХАСХОМ хэрхэн гаргах тухай сургалт явуулсан. Мөн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй захиргааны актуудыг нягтлан шалгаж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан цахим сургалт”-нд аймгийн төр, төсвийн байгууллагуудын 26 ЭБАТ-ыг оролцуулсан.

Хууль сахиулах байгууллагуудын ажил хэргийн уулзалт, сургалт, зөвлөгөөний 2017 оны хуваарь, ажилтан, алба хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, туршлага солилцох сургалт зөвлөгөөний хуваарийг тус тус батлан хууль сахиулах байгууллагуудад хүргүүсэн.

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 701 холбогдогчтой, 1465.3 сая төгрөгийн хохиролтой, 669 гэмт хэрэг бүртгэгдэж, 124 хэргээр буюу 15.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн гаралт Сүхбаатар сумын 4-р баг, Алтанбулаг, Шаамар, Дулаанхаан тосгон, Ерөө, Бугант тосгон, Түшиг, Сант сумдад 4.4-77.8 хувиар өсч, Сүхбаатар сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8 дугаар багууд, Хүдэр, Жавхлант, Мандал, Баянгол, Сайхан, Орхонтуул, Баруунбүрэн сумдад 7.1-76.9 хувиар тус тус буурч, Орхон суманд өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн үйлчилгээнд 2017 оны 1 дүгээр сард 166 төрөлт, 37 гэрлэлт, 51 нас баралт, 385 иргэнд цахим үнэмлэх, 84 үндэсний энгийн гадаад паспорт, ОХУ-ын хавсралт 4697 ширхэг олголтыг хийж, аймаг, хотруу шилжин явсан 219, шилжин ирсэн 255, сум дүүрэгт шилжин ирсэн 103, сум дүүрэгт шилжин явсан 94, баг хооронд шилжин ирсэн 222, баг хооронд шилжин явсан 219 шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна. Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлд 442 бүртгэл, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын 634 бүртгэл бүртгэгдэж, улсын тэмдэгтийн хураамж 132300, үйлчилгээний хураамж 7691863 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татвар 6896000 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

2. Архивын талаар

Сэлэнгэ нутгийнхаа түүхийн эрдэнэсийн сан болсон архивын хөмрөгийн баримтыг сурталчлан дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэнд оруулж иргэд, үйлчлүүлэгчдэд ая тухтай орчинд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор “Уншлагын танхим”-ыг засварлаж ашиглалтанд оруулан хяналтын камер, бичигч төхөөрөмж, хард диск, зурагтын дэлгэц, свеч, тэжээлийн болон сүлжээний утас, ширээ, сандал, хувцасны өлгүүр, жааз зэрэг техник хэрэгсэл байршуулсан. Тайлант сард цахим болон цаасан суурьтай баримтаас архивын хуулбар 281, үүнээс цахим хэлбэрээр 264, цаасан суурьтай баримтаас магадлагаа 17, тодорхойлолт 27, эхийн одонгийн лавлагаа 26, цалингийн тодорхойлолт 11-ийг гарган давхардсан тоогоор 300 гаруй иргэнд үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн “Сэтгэл зүйн үйлчилгээний үндэсний төв”-тэй хамтран цэцэрлэгийн болон ЕБС-ийн багш нарын сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Багшлах ажлын сэтгэл зүй” сэдэвт 2 кредит цагийн сургалтыг 2017 оны 01 дүгээр сарын 20, 21-ний өдрүүдэд Сүхбаатар сумын 3, Хөтөл хотын бүрэн дунд сургууль дээр зохион байгуулж, 200 гаруй багшийг оролцуулсан. Сургалтаар сургалт, хүмүүжлийн ажлын явцад суралцагчдыг судлах арга зүй, анги удирдсан багшийн ажлын сэтгэл зүй, хичээлээс гадуурх ажлын сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх харилцааны сэтгэл зүйн асуудал, эцэг эхтэй ажиллах ажлын

сэтгэл зүй, бүлэг, хамт олны сэтгэл зүй, багшийн удирдах менежмент зэрэг багшийн ажлын байранд тавигдах үндсэн шаардлагын дагуу багшийг ажлын байран дээр нь хөгжүүлэх чиглэлээр сургалтыг явуулсан нь багш нарт үр дүнтэй байлаа.

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2016 оны 12-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 856 байсан бол 60 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 17 ажлын байранд 15 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 67 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 834 болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас 1-р сарын 25-ны байдлаар 3025 иргэнд 300,000,000 төгрөгийг олгоод байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1689 иргэнд 240,000,000 төгрөг
- Жирэмсэн, хөхүүл нярай хүүхэдтэй 1259 эхэд 50,000,000 төгрөг
- Ахмад настны тусламж, хөнгөлөлт 77 иргэнд 10,000,000 төгрөг

3.Нийгмийн даатгалын талаар:

2017 оны 01 сарын 24-ний байдлаар Эрүүл мэнд, Нийгмийн даатгалын хэлтэс нь Нийгмийн даатгалын сангуудад 1654,5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгээс 1675,6 сая төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 100,1 хувьтай байна.

Аймгийн Удирдах ажилтны зөвлөгөөний үеэр сум, баг, хэлтэс агентлагийн удирдлагуудад нийгмийн даатгалын тухай ойлголт, ач холбогдлын талаар гарын авлага тарааж мөн “Өргөн Сэлэнгэ” сэтгүүлд “Чанартай үйлчилгээ-соёлтой харилцаа аян” “Тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах аян”, нийгмийн даатгалын тухай ерөнхий ойлголтын талаар мэдээлэл өгч, орон нутгийн “Таны сэлэнгэ”, “ММЭ” телевизүүдэд тэтгэвэр авагчдын тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгах, одоо авч байгаа тэтгэврийн хэмжээг баталгаажуулах аяны талаар яриа өгч, шторк гаргаж, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын хуралд иргэдэд нийгмийн даатгалын тухай ойлголт өгөх зорилгоор видео бичлэг явуулж танилцуулга хийсэн.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг 1537,5 мянган төгрөгөөр барагдуулж ажиллалаа. 2016 оны хуримтлагдсан өр авлагатай хувь хүн болон аж ахуй нэгжүүдээс 13 байгууллагын 18701428 төгрөгийн нэхэмжлэлийг шүүхэд өгч мөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2 байгууллагын албадан гүйцэтгүүлэх тухай захирамж гарч хамтран ажиллаж байна.

4.Эрүүл мэндийн талаар

“Халуун сэтгэл-2017” аяны хүрээнд дотор, ЭХО, эмэгтэйчүүд, хүүхэд зэрэг нарийн мэргэжлийн эмч нарын баг сум, багийн дарга болон багийн эмч нар багтсан багийн ард иргэдийн эрүүл мэндийн төлөө хамтран турш нийт 606 өрхийн давхардсан тоогоор 2121 иргэнд хүрч үйлчилсэн.

Австрали улсын Гриффитийн их сургуулийн хүмүүнлэгийн сургуулийн професор Хамыш ЭМЯ-ны ЭТГ-ын ахлах мэргэжилтэн Ч.Баярмаа нар Баруунбүрэн, Сайхан сумдын эмнэлгийн яаралтай тусламжийн тасагтай танилцаж, Сайхан сумын сум дундын эмнэлэг, Номгон, Орхон, Сант, Баруунбүрэн, Баянгол сумдын Эрүүл мэндийн төв, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн 46 эмч, тусгай мэргэжилтнүүдэд “Гамшиг онцгой байдлын үеийн эрүүл мэндийн салбарын манлайлал” сэдвээр 1 өдрийн сургалтыг зохион байгууллаа.

5.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Өсвөрийн шатарчдын “Цодгор хүү-2017” аймгийн аварга шалгаруулах уралдааныг Мандал суманд зохион байгуулж, 13 насны ангиллаар 8 сумын 18 багийн 170 хүүхдийг хамруулж, 13 хүүхдийг Н.Төрбатын нэрэмжит улсын уралдаанд оролцууллаа.

Хүүхдийн тусламжийн утас 108-аас ирсэн 6 кейс дээр ажиллаж хариу үйлчилгээ үзүүлж байна.Улаанбаатар хотод болсон Хүүхэд, залуучууд, гэр бүлийн асуудлаар үүрэг хүлээгчдийн нэгдсэн сургалтанд 1 удирдах ажилтан, 3 мэргэжилтэн хамрагдав.

“Хүчирхийллийн эсрэг хамтдаа” сургалтыг нийт 34 сургуулийн 9-12 ангийн сурагчдад зохион байгуулахаар удирдамж, хичээлийг орон нутгуудад хүргүүлээд байна.

Аймгийн “Хүүхдийн төлөө зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж, түүний дүрмийг гардуулан өгч, 2017 онд хийх жилийн ажлын төлөвлөгөө гаргах, шинээр гишүүд элсүүлэх талаар ярилцан арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Залуу гэр бүлийг дэмжих, Монгол зан заншлаа эрхлэн дээдлэх, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор гэрлэж байгаа 1 хосд гэрлэлтийн баталгаа гардуулах, гэр бүлийн тангараг өргүүлэх үйл ажиллагааг “Хүндэтгэлийн танхим”-д зохион байгууллаа.

Хүүхэд харах үйлчилгээ эрхлэгч иргэдийн анхан шатны 1 дүгээр сарын бүртгэлийн мэдээг Алтанбулаг, Шаамар, Зүүнбүрэн, Сант, Баруунбүрэн, Ерөө, Мандал, Сайхан, Сүхбаатар сумаас авч нэгтгэсэн бөгөөд 9 сумын 12 төвөөр нийт 180 хүүхэд бүртгэгдэж үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхэд байна.

Аймгийн 17 сумын хамтарсан багтай хамтарч “Сайн эцэг, эх” сургалтыг архины хамааралтай, Цагдаагийн байгууллагын хяналтанд байдаг, зорилтот бүлгийн эцэг эхэд архи согтууруулах ундааны эрсдлийн түвшинг оношлох, эрсдлийг бууруулах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг ойлгуулах зорилгоор зорилтот бүлгийн өрхийн 152, залуу гэр бүл 115, нийт 267 хүнийг хамруулан зохион байгууллаа.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн нийт сумдын мал нэмэгдэл тэжээлд орсон, 01 дүгээр сарын байдлаар нийт 1221 мал хорогдсон үүнээс хээлтэгч мал 115, өвчнөөр 16 бусад зүй бусаар хорогдсон, Хушаат, Зүүнбүрэн, Ерөө, Цагааннуур сумдын нутгаар цас ихтэй байгаагаас малын бэлчээрлэлт саатаж, өвөлжилт хүндэрсэн. Цаашдаа цас их хэмжээгээр орж, хүйтний эрч чангарвал ихэнх сумдын нутгаар өвөлжилт хүндрэх эрсдэлтэй байна. Үүнтэй холбогдуулан аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөөс 94 тн өвс, 50 тн хивэг, 10 тн уурагжуулсан тэжээлийг сумдад хуваарилан 02 дугаар сарын 01-нээс малчдад хөнгөлөлттэй үнээр борлуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна. Их Британи болон Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн Гамшгийн менежментийн хөтөлбөрийн хамтарсан баг тус аймгийн зудтай сумдад ажиллаж, Жавхлант, Шаамар сумдын малчин өрхүүдээр явж зудын байдалтай газар дээр нь танилцаж 8 сумын 152 өрхөд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнтэй тэнцэх мөнгөн тусламжийг олгохоор шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 394 дүгээр тогтоолын дагуу сумдаас давхардсан тоогоор 2032 малчны 119488 ширхэг арьс ширийг дотоодын үйлдвэрлэл нийлүүлсэн тухай материалыг хүлээн авч Мал хамгаалах санд хүргүүлэхэд бэлэн болгосон.

Мөн өнгөрсөн 12-р сарын 31-нд тус аймгийн Хүдэр суманд цэцэг өвчний сэжиг илэрч, гоц халдварт А040 өвчин болох нь оншлогдогдсон бөгөөд уг өвчинтэй тэмцэх зааврын дагуу хорио цээрийн дэглэм тогтоож, үзлэг танадалт, вакцинжуулалт, өвчтэй малыг илрүүлэх, устгах ажлыг зохион байгуулж нийт 9 голомтонд /суурь/ 1657 хонь өвчилснийг устгасан. Мөн 2016 оны жилийн эцэст тус суманд тоологдсон 14211 толгой хонь болон зэргэлдээ Алтанбулаг, Ерөө, Жавхлант сум болон Дархан Уул аймгийн Хонгор сумтай хил залгаа Хушаат, Баянгол сумын нийт 192800 толгой хонь вакцинжуулахаас 949 өрхийн 190945 толгой хонийг уг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд хамруулж хамгаалалтын бүс үүсгэсэн.

Монгол Улсын "Улсын аварга тариаланч хамт олон"-оор Хушаат сумын "Өгөөж мандал уул" ХХК, "Мон агро" ХХК, Цагааннуур сумын "Атар трейд" ХХК, "Сэлэнгэ тариа" ХХК, Хүдэр сумын "Ургац хүдэр" ХХК, "Арвин тариа" ХХК, Ерөө сумын "Их шинэстэй" ХХК, "Улсын аварга тариаланч"-аар Цагааннуур сумын "Товханхан" ХХК, Хушаат сумын "Элит үр" ХХК, "Өгөөж мандал уул" ХХК, Хүдэр сумын "Ургац хүдэр" ХХК-ийн техникч, агрономич нарын материалыг, 2016 онд сум хөгжүүлэх сангаас 90 зээлдэгчид 531 сая төгрөгийн зээлийг олгож, 1970 гаруй шинэ ажлын байр бий болгож, 571 ажлын байр хадгалагдсан тухай мэдээлэл, 2016 оны улаанбуудайн

урамшуулал олгох журмын дагуу 190 аж ахуйн нэгж, 71 иргэний материалыг хүлээн авч хянан тус тус ХХААХҮЯ-д хүргүүлсэн.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, Байгаль орчны бодлогын хүрээнд:

1. Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 13 бараа, ажил үйлчилгээнд 282.0 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 8 бараа, ажил үйлчилгээнд 1137.0 сая төгрөг, замын сангийн хөрөнгө оруулалтаар 18 бараа, ажил үйлчилгээнд 513.0 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 6 бараа, ажил үйлчилгээнд 433.2 сая төгрөгөөр нийтдээ 45 бараа, ажил үйлчилгээнд 2083.2 сая төгрөг зарцуулахаар аймгийн 2017 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Сүхбаатар сумын барилгын 27 дугаар байрыг хэрэглээний халуун усны шугамд холбох, Шаамар сумын шинэ цэцэрлэгийн гадна тоглоомын талбай байгуулж, хашаа барих, Алтанбулаг сумын 64 айлын нийтийн орон сууцны дотор сантехник засвар, Баруунбүрэн сумын сургуулийн дотуур байрны барилгын засвар, Хүдэр сумын Засаг даргын тамгын газрын их засвар, Сүхбаатар сумын 7 дугаар баг, төмөр замын байруудыг хэрэглээний халуун усаар хангах, Орхон сумын сургуулийн дээвэр засвар зэрэг ажлуудын ажлын даалгавар, хийгдэх ажлын тоо хэмжээг, БНХАУ-ын хөрөнгө оруулалтаар аймгийн төвд баригдах 50МВт-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станцын байгаль орчныг хамгаалах суурь мэдээлэл, эрх зүйн мэдээлэл, агаар, ус, хөрсний бохирдлын мэдээлэл, байгаль орчны стандартуудын талаар холбогдох баримт бичгийг боловсруулж эхлээд байна.

www.selenge.gazar.gov.mn цахим хуудсанд цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилж, газрын харилцааны албан хэрэгцээнд ашиглагддаг аймагсад мэдээллийн сангийн баазад тайлант сард нийт 16 сумын газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарын 85 нэгж талбар хувийн хэргийн мэдээллийг уг программд оруулж, Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээний болон шатахуун түгээх станцын зориулалтаар 4 нэгж талбарт цахим дуудлага худалдааг зохион зохион байгуулсан.

2. Байгаль орчны талаар:

2017 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг аймгийн ИТХ-аар батлуулж, аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн огтлолтоор хэрэглээний мод 15500 шоо метр, арчилгааны огтлолтоор 5800 шоо метр, цэвэрлэгээний огтлолтоор 14800 шоо метр, цэвэрлэгээний ажлаар 9000 шоо метр нийт 45100 шоо метр хэрэглээний мод, 82850 шоо метр түлээний мод бэлтгүүлэхээр тогтоосныг сумдын ИТХ, сумын болон сум дундын ойн ангиудад мод бэлтгэлийг хуулийн хүрээнд явуулах, мод бэлтгэлийн талбайг тусгаарлах талаар зөвлөмж хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд буюу энэ сарын 1, 8, 9, 17, 20-нд бүх сумдын нутгаар 0,0-3,0 мм, 7, 16, 18-нд нутгийн хойд хэсгээр 0,0-1,0 мм цас орсон. Ихэнх хугацаанд салхи баруун хойноос болон баруунаас 2-7 м/сек хурдтай. Нийт нутгаар 15-34 см зузаан цасан бүрхүүлтэй байна. Ерөө, Цагааннуур, Зүүнбүрэн, Хүдэр, Түшиг, Ерөө сумдын нутгаар цасны зузаан 25-24 см нягт нь 0,14-0,16 г/м³ байна. 1-р арав хоногт шөнөдөө 25-30 градус, өдөртөө 13-18 градус, 2-р арав хоногийн сүүлээр хүйтэрч шөнөдөө 35-43 градус, өдөртөө 22-27 градус, бусад хугацаанд шөнөдөө 33-38 градус, өдөртөө 20-25 градус хүйтэн байлаа. Сэлэнгэ мөрөн 62-82 см, Орхон гол 89 см, Ерөө гол 73-81 см, Хараа гол 92 см, Зэлтэр гол 67 см, Хүдэр гол 54 см зузаан мөстэй байна. Аймгийн төв Сүхбаатар суманд агаарын бохирдол, гадаргын усны гидрохимийн шинжилгээ, цацрагийн түвшин нь стандарт хэмжээнээс хэтрээгүй байна. Агаар дахь түгээмэл бохирдуулагч хий болох азотын давхар ислийн дундаж агууламж 0,034мг/м³, хамгийн их агууламж 0,059 мг/м³, хүхэрлэг хийн дундаж агууламж 0,007 мг/м³, хамгийн их агууламж 0,011 мг/м³ байсан.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Алтанбулаг сум

Монгол Улсад анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдсаны 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ЕББДС-ийн 12 дугаар ангийн 47 сурагчид мэдээлэл хийсэн. Мөн сумын 2016 оны аваргуудыг тодруулан алдаршуулсан.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын хил орчимд иргэдийн хамгийн их бухимдалтай байдаг асуудлын нэг бол орчин үеийн бие засах газаргүй гэдэг асуудлыг аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж, аймгийн "СҮЛД ХАНБА" ХХК гүйцэтгэн хил орчимд нийтийн 00 ашиглалтанд оруулсан.

Өвөлжилт, цаг үеийн мэдээ мэдээллийг малчдад хүргэх, цэцэг өвчний вакцинд хамруулах зорилгоор сумын ажлын хэсэг 3 чиглэлд ажиллаж, 101 суурийн 21600 хонийг вакцинжуулсан. Мөн сумын оршин суугчдын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэдгээрийн амьдрах аюулгүй орчинд үйл ажиллагаа явуулах, бага болон сургуулийн насны хүүхдүүдийн хичээлдээ явах, тарах үеийн аюулгүй байдлыг хангах үүднээс золбин нохой устгах ажлыг зохион байгуулж, 200 гаруй нохойг мэргэжлийн байгууллагаар устгуулах арга хэмжээ авлаа.

Ерөө сум:

Сумын 2017 оны 01-р сарын 20-ны өдрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017 оны төсөвт оруулах тодотгол, Газар зохион байгуулалтын 2016 оны тайлан, 2017 оны төлөвлөгөө, 2016 онд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан 89 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тус тус хэлэлцэж, сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид 2017 оны 01-р сарын 23-ны өдөр 2016 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаа тавьж, 120 гаруй иргэд хамрагдсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 151 дүгээр зарлигаар анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдаж мөрдөж эхэлсний 25 жилийн ойг тохиолдуулан Төрийн захиргаа хууль эрх зүй дотоод ажил хариуцсан ажилтан Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 88 сурагчдад "Үндсэн хуулийн ойлголт" сэдвээр сургалт хийж, Үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж, 24 бөх зодоглосноос Сэлэнгэ аймгийн Сант сумын харъяат Таван хан дэвжээний бөх аймгийн начин Н.Батмөнх түрүүлж, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын харъяат Таван хан дэвжээний бөх аймгийн арслан М.Жаргалсайхан үзүүрлэж, Дархан уул аймгийн Шарын гол сумын харъяат аймгийн харцага Ж.Бадрал шөвгөрлөө.

Мэргэжлийн хяналтын газраас Улаанбаатар хотод архинд хордож хүн нас барсан тухай мэдээлэл ирүүлсэнтэй холбогдуулан тусгай зөвшөөрөлтэй 13 аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт, зөвлөн утслах ажлыг зохион байгуулж, аймгийн Засаг даргын А/21 тоот захирамжийг холбогдох газруудад хүргүүлж ажилласан.

Ерөнхий боловсролын 12 жилийн дунд сургуулиас “Эцэг эхчүүдийн нэг өдөр” спортын өдөрлөгийн арга хэмжээг зохион явуулж, 1-12 ангийн нийт сурагчдын эцэг эхчүүд гар бөмбөг, ринго, хөгжилтэй буухиа гэсэн 3 төрлийн тэмцээн болж, 187 эцэг эхчүүд оролцлоо.

Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 1/02 тоот албан бичгийг үндэслэн сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 2017 оны 01 дүгээр сарын 05-13 өдрүүдэд 1, 2, 3-р багийн 273 өрх, 3 аж ахуйн нэгж байгууллагын 32800 хонинд малын гоц халдварт цэцэг өвчнөөс сэргийлэх вакцин тарилга хийж, өвөлжилт хүндэрсэн малчин айл өрхүүдээр ажиллаж, өвс тэжээлийн нөөцөөс 880 боодол өвс, 245 шуудай буюу 6 тн хивэгийг 44 айл өрхөд, 20 айл өрхөд 672 кг хужир хөнгөлөлттэй үнээр олгож, малчин, мал бүхий иргэд, худалдаа үйлчилгээний газруудад “Малын гоц халдварт цэцэг өвчний” талаарх мэдээлэл, зөвлөгөө өгч гарын авлага тарсан.

Зүүнбүрэн сум:

Ардчилсан шинэ үндсэн хуулийн 25 жилийн ойг тохиолдуулан сумын иргэдэд сургалт сурталчилгаа, ахлах ангийн сурагчдын дунд ЭССЭ бичлэгийн уралдааныг зохион байгуулснаас гадна тус сумаас депутатаар сонгогдон ажиллаж байсан

М.Доржсүрэнд сумын ИТХ, Засаг дарга хүндэтгэл үзүүлж, төрийн албан хаагчдад мэдээлэл хийсэн. Мөн соёлын төвийн номын санд үндсэн хуулийн буланг байршуулан иргэдэд мэдээлэл хүргэлээ.

Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж, сумын хэмжээнд 700 иргэн хамрагдахаас 560 иргэн хамрагдсан.

Эцэг эхчүүдэд хүүхдийг хүмүүжүүлэх эерэг аргуудын талаар мэдлэг олгох, хандлагыг өөрчлөх, ёс зүйг төлөвшүүлэх, гэр бүлийн харилцаа хандлагыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сайн эцэг эх” сургалтыг зохион байгуулж, 35 иргэнийг хамруулсан.

Жавхлант сум:

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2. дахь заалтын дагуу Багийн ИНХ, Засаг дарга нарын сонгууль болж, Бумбат 1-р багийн иргэдийн Нийтийн Хурлын даргаар Д.Энхтөр, Засаг даргаар Ц.Дарханбаатар, Моностой 2-р багийн иргэдийн Нийтийн Хурлын даргаар Н.Ганхуяг, Засаг даргаар Д.Удвал нар сонгогдсон.

Монгол Улсын анхны ардчилсан “Үндсэн хууль” батлагдаж мөрдөж эхэлсний 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд 1924, 1940, 1960, 1992 онуудын Үндсэн хуулиудаар сургалт зохион байгуулж гарын авлага тарааж, ЕББДСургуулийн ахлах ангийн сургачдад цахим хичээл орж тэдний дунд “Хууль ба Үндсэн хууль” сэдэвт ЭССЭ бичлэгийн уралдааныг явуулсан.

Монгол Улсын цэргийн албаны тухай хуулийн дагуу 2017 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийг явуулан 18-50 насны 1, 2-р зэргийн нийт 375 иргэн бүртгэгдэж, дүн мэдээг аймгийн цэргийн штабт хүлээлгэн өглөө.

Сумын ИТХ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг хөдөөгийн малчин 84 өрхөөр ажиллан өвөлжилтийн байдал, өвс тэжээлийн нөөц, санал хүсэлтийг сонсох, айл өрхүүдийн хооронд зам гаргах, хүн, мал эмнэлийн үйлчилгээ үзүүлж, сумын онцгой комисс 3 удаа хуралдаж малын цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын тухай, өвөлжилтийн цаг үеийн нөхцөл байдлын тухай болон өвөлжилт хүндэрсэн нутаг, өрх малчдад тусламж дэмжлэг үзүүлэх зам бэлчээр гаргах тухай хэлэлцэж, сумын төвд хариуцлагатай жижүүрийг тогтмол хуваарийн дагуу ажиллуулж тухай бүр аймгийн Онцгой байдлын газарт холбогдох мэдээлэл, судалгааг шуурхай хүргэж, байна. Малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд нийт 217 өрхийн 45640 хонинд хийлээ.

Улсын сайн малчин, аймгийн сайн малчин, аймгийн алдарт уяач, тэргүүний тариаланч хамт олон, салбарын тэргүүнээр шалгаруулах хүмүүсийг тус тус тодорхойлон аймгийн Засаг даргад уламжилж, арьс ширний урамшуулалд хамрагдах 529 иргэний материалыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Орхон сум:

Сумын Засаг дарга, ИТХ-ын дарга нар төр төсвийн байгууллагуудын өвөлжилт болон цаг үеийн мэдээлэл, ажилтан албан хаагчдын санал хүсэлтийг сонсож байгууллагын үйл ажиллагаатай холбоотой зарим асуудлыг шийдвэрлэж, цэцэрлэгийн багшийн сургалтын үйл ажиллагаанд зөөврийн /Lenovo/ компьютер 2 ширхэг, ЕБСургуульд ухаалаг зарлан мэдээллийн систем олгож, ЭМТ-д шаардлагатай байгаа асуудлыг сонсож хэвтэн эмчлүүлж буй 6 иргэн, 2 хүүхдэд эргэлт үзүүлж ажиллалаа.

Монгол Улсад шинэ үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан тус сумаас сонгогдон шинэ үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын депутат, МУ-ын гавъяат эдийн засагч А.Амжаа агсаны үр хүүхдүүд, Мангир трейд ХХК-тай хамтран А.Амжаа агсаны нэрэмжит Гар бөмбөгийн тэмцээн, үдшийн цэнгүүн, танин мэдэхүйн АХА тэмцээн зэргийг зохион байгуулж тус арга хэмжээнд давхардсан тоогоор 243 иргэнийг хамруулж, Орхон бүсийн шагайн харваа тэмцээнийг явуулж, тэмцээнд 6 багийн 42 харваач оролцлоо.

Сумын Засаг даргын захирамжаар малчдад туслах "Сайн үйлсийн аян"-ыг 2017 оны 01-р сарын 01-нээс 2-р сарын 15-ыг хүртэлх хугацаанд зохион байгуулахаар шийдвэрлэн эхлүүлж, Сайхан сумын аврах гал унтраах 61-р анги, Ахмадын хороо

малчдад бээлий, лаа шүдэнз, Орхон суманд үйл ажиллагаа явуулдаг Зуун зуун ХХК-аас 50 боодол өвсийг малчдад туслахаар хүлээлгэн өглөө. Тус аяны хүрээнд сумын төр төсвийн байгууллага төрийн албан хаагчид малчдад туслах “Хишиг өдөр” арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Мөн цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэх зорилгоор хөдөөгийн багт 4 чиглэлд ЗДТГазар, ЭМТ, Цаг уур хамтран ажлын хэсэг гарч нийт 166 малчин, мал бүхий иргэдээр ажиллаж 1, 2-р сарын цаг агаарын урьдчилсан мэдээ, өвлийн улиралд ядарч доройтсон малыг тэжээх арга болон ядарсан малд нэмэлтээр олгож болох эм бэлдмэлийн талаар гарын авлага бэлтгэн тарааж, цаг агаарын мессеж мэдээнд 57 өрхийг хамруулсан. Сумын хэмжээнд 10-р сараас хойш нийт 27 удаа цас орж цасны зузаан 9-21 см, цасны нягт 0,14 байна. Тус сумын Дэргээч, шийр, ажинт, худгийн хоолой, бор харганат, сумын төвд цас ихтэй байгаа боловч өвөлжилт хүндэрсэн газар нутаг байхгүй байна. Ар булан, Цант, ажинт, шийр, сайхны ам чиглэлийн зарим газраар цас хатуурснаас үхрийн хөл халцарч байгаа талаар малчид мэдээлсэн. Малчид, мал бүхий иргэд өвс тэжээлээ тодорхой хэмжээгээр бэлтгэсэн боловч бэлчээр муудаж байгаагаас 5 өрхийн өвс хүрэлцэхээргүй байна. 1-р сарын 19-ны өдөр Орхон сумын Багийн Засаг даргыг сонгох сонгууль болж 1-р багийн Засаг даргаар Баянжаргалын Сийлэгмаа, 2-р багийн Засаг даргаар Нямжавын Төрсайхан нар сонгогдлоо.

Орхонтуул сум:

Тус сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулж сумын ИТХ-н нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлууллаа. Аймгийн Засаг даргын 2016 оны А\346 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Өрсөлдөөний тухай, Зар сурталчилгааны тухай хуулиудын хэрэгжилтийг хангах орон тооны бус зөвлөлийг Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулж иргэдэд сурталчилсан. Монгол Улсад шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийг түүхийг харуулсан зурагт самбар гарган иргэдэд танилцуулж, гар бөмбөг, шагайн харваан тэмцээн зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Зөвлөл хуралдаж Зөвлөлийн 2017 оны ажлын төлөвлөгөө, Удирдах ажилтнуудын зөвлөгөөн зохион байгуулах тухай, Хонины гоц халдварт цэцэг өвчнөөр өвчилж зориудаар устгасан малд нөхөн төлбөр тооцуулах материал бүрдүүлэх, холбогдох газарт нь хүргүүлэх тухай болон сумын Малчдын зөвлөгөөний тов тогтоох асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, сумын “Удирдах ажилтнуудын Зөвлөгөөн”-ийг 01-р сарын 20-ны өдөр зохион байгуулж 2016 онд хийсэн ажлуудын амжилт ололт, алдаа дутагдлаа ярилцаж, 2017 онд хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн төсвийн Ерөнхийлөн захирагч Төсвийн шууд захирагч нартай Үр дүнгийн гэрээ байгуулсан. Сумын нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч, даатгуулагчаас 01-р сарын 24-ний байдлаар 5500,0 мянган төгрөгийн шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 921.6 мянган төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон. Тус сумаас их, дээд сургуульд суралцаж байгаа оюутан залуусыг дэмжих зорилготой “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-т 2016 онд шалгарсан 5 оюутанд тус бүрт нь 500,000 төгрөгийн тэтгэлэг олголоо.

Малын гоц халдварт “Цэцэг” өвчин гарсан 35 малчин өрхөөр орж малд нь үзлэг хийж цаашид ажиллах ажлын чиглэл өгч, малчдаас өвс тэжээлийн захиалга авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт 40 тн тэжээлийн захиалга хүргүүллээ. 2016 оны жилийн эцсээр тэмээ 410, адуу 13726, үхэр 19557, хонь 106511, ямаа 75856 тоологдсоноос 1-р сард адуу 11, үхэр 8, хонь 49, ямаа 51 бүгд 119 толгой мал хорогдсон нь оны эхний малын 0,01% -ийг эзэлж байна. Одоогийн байдлаар төллөх 962219 хээлтэгчээс 1-р сарын 20-ны байдлаар үнээ 32, хонь 94 төллөөд байна.

Сайхан сум:

Монгол Улсын “Үндсэн Хууль”-ийн 25 жилийн ойг угтан сумын Засаг даргын Тамгын газраас төлөвлөгөө гарган зохион байгуулсан. БНМАУ-ын Ардын Их Хурлын 12 дахь удаагийн сонгуулиар Номгон САА-аас 299 дүгээр тойрогт сонгогдож,

“Ардчилсан шинэ Үндсэн хууль” батлалцсан АИХ-ын депутат Гүржавын Сүрэнжаргал гуайд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж, орон нутгийн телевизтэй хамтран уулзалт-нэвтрүүлэг бэлтгэн, сум орон нутгийн иргэд, олон нийтэд хүргэж, сумын хэмжээнд 14 төр, төсвийн байгууллагын 300 гаруй төрийн албан хаагчид Үндсэн хуулийн таниулах сургалтыг зохион байгуулав. Мөн сумын Ерөнхий боловсролын 2 сургуулийн 715 суралцагчдад Үндсэн хуулийг таниулах, үнэ цэнийг танин мэдүүлэх, хүний эрхийн боловсрол олгох зорилгоор 12-р ангийн суралцагчдын дунд “Дэвжээ” тэмцээн, “Алтан хонх” уралдаант тэмцээн, “ЭССЕ” бичлэгийн уралдаан, дунд ангийн суралцагчдын дунд зохион бичлэгийн уралдаан, “Үндсэн хуулиа дээдлэе” хэлэлцүүлэг, 6-12 дугаар ангийн суралцагчдын дунд Үндэсний бөхийн барилдааныг тус тус зохион байгуулж, шагнаж урамшуулсан. 2017 оны 01-р сарын 21-ний өдөр эрүүл агаарт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Сайхан сумын албан газар, аж ахуйн нэгж байгууллагуудын дунд нийтийн биеийн тамир спортын олон төрөлт тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд 12 байгууллагын 300 гаруй албан хаагч амжилттай оролцлоо. Уг өдөрлөгт уулын оргил булаацалдах, дардас шидэлт, хөгжилтэй буухиа, “Шилдэг отог” шалгаруулах гэсэн 4 төрлөөр өрсөлдөж шилдгүүдээ шалгаруулсан.

Сайхан сумаас арьс ширний урамшуулалд хамрагдах 100 гаруй малчин, мал бүхий иргэдийн 387 ширхэг паданыг ARIS программд шивж, бусад холбогдох арга хэмжээг авсан. 2017 онд хувийн хэвшлийн мал эмнэлгүүдийн ажил үйлчилгээ үзүүлэх малчин, мал бүхий иргэдийн хоорондын гэрээ болон малын тоо, шаардагдах эм бэлдмэлийн захиалга хүсэлтийг батлуулсан. Мөн өвөлжилт хаваржилт байдал, сумын аюулгүй нөөц бэлтгэсэн өвс тэжээлийн зарцуулалтыг үлдэгдэлтэй нь судалгааг гаргасан.

Сант сум:

Монгол Улсын Шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн хүрээнд “Үндсэн хуулийн тухай ойлголт, Үндсэн хуулийн түүхэн замнал” сэдэвт сургалт мэдээллийн ажил зохион байгуулагдаж 38 иргэн, ахлах ангийн 54 сурагч хамрагдсан байна.

Мөн Орхон бүсийн сургуулиудын хамтын ажиллагаа, багш, ажилчдын бие бялдрыг хөгжүүлэх, урлаг спортын арга хэмжээнд өргөнөөр оролцуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор тус суманд зохион байгуулж, нийт 8 баг оролцож, 1 –р байрт Сайхан сумын баг, 2 –р байрт: Орхонтуул сумын баг, 3 –р байрт Орхон сумын багууд тус тус шалгарсан байна.

Мал аж ахуйн түргэвчилсэн байдлын үнэлгээ, сумын төвд мал өвөлжүүлж байгаа өрх болон сумын төвөөс алслагдсан, өвөлжилт хүндэрсэн өрхүүдийн судалгаа, сумын малчдын өвс тэжээлийн хүрэлцээ хангамжийн судалгааг гарган холбогдох газарт хүргүүлсэн ба мал төллөлт болон том малын хорогдлын мэдээгээр 1 дүгээр сарын 23-ны байдлаар сумын хэмжээнд адуу 4, үхэр 27, хонь 11 нийт 42 толгой мал хорогдсон байна. Сумын төвөөс Хушаат суурин болон Дулааны ар, Үзүүр Цохио орох чиглэлийн зам даваа цасанд боогдож онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан сумын удирдлагууд болон дүйцүүлэх албаны цэргүүд оролцсон 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хаагдсан зам давааг онгойлгож хэвийн байдалд оруулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 394 дүгээр тогтоолоор батласан Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс шир тушаасан малчин өрх, мал бүхий иргэнд мөнгөн урамшуулал олгох журмын дагуу 398 өрхийн 6881 арьс ширэнд мөнгөн урамшуулал олгуулахаар баримт материалыг бүрдүүлж Мал хамгаалах санд явуулсан байна.

Хушаат сум:

Шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан 1992 онд сумын депутатаар сонгогдсон сум САА-н анхны дарга Х.Намсрайжавын хөрөг нийтлэлийг сумын fb хуудас, “Миний монгол “ ТВ, Control.mn сайтуудад нийтэлж, сумын аварга шалгаруулах шатрын тэмцээн, 16 нас хүрч иргэний үнэмлэх гардаж буй иргэний “Андгай өргөх ёслол”, “Үндсэн хуулийн видео хичээл”, “Бүртгэл чиний амьдралд” зэрэг сургалтуудыг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, “Өгөөж мандал уул” ХХК-ууд хамтран “Хүнд өвлийг хүнлэг сэтгэлээр туулья” арга хэмжээг зохион байгуулж өвөлжилт хүндэрсэн малчин өрхүүдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж,

нийт 1865 иргэнд “Томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх” гарын авлагыг тараан, нийт 563 өрхийг үзлэгт хамруулж, ЭМТ-ийн автомашинд аймгийн хөрөнгө оруулалтын 5,0 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл авч хэвийн үйл ажиллагааг хангалаа. Цэцэрлэгийн хүүхдүүд, багш, туслах багш нарт цэгэн массаж хийх аргачлал сургалт явуулж, 8 багш, 64 хүүхэд хамрагдан, ханиад томуугаас урьдчилсан сэргийлэх зорилгоор “Витаминжуулалт” 1 сарын аян зохион байгуулж хүүхдүүдийн өвчлөлийн судалгааг гарган өглөөний 11 цагийн цайнд чацаргана, аарц буцалган өгч хэвшсэн.

Сумын Статистикийн тайлан, мэдээ судалгааны графикийг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сумын хэмжээнд 430 том мал зүй бусаар хорогдсон ба мал төллөлт эхэлж, сумын хэмжээнд 56 төл гарснаас тугал 51, ишиг 5 толгойгоор нэмэгдэн эсэн мэнд бойжиж байна. Аймгийн өвсний нөөцийг тус суманд бүрдүүлж 3500 боодол өвсийг хүлээн авч харуул хамгаалалттай хашаанд байрлуулан “Алтан тариа” ХХК-иас 6 тн хивэгийг татан авч малчдад түгээх ажлыг зохион байгуулж, малчдын үндэсний үйлдвэрт тушаасан арьс ширний материалыг хүлээн авч тулгалт хийн шивж 132 өрхийн 378 баримтыг журмын дагуу холбогдох дээд шатны байгууллагад уламжилж, малын цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг сумын 74 малчин өрхийн 15800 хонинд хийлээ.

Хүдэр сум:

Суманд малын гоц халдварт цэцэг өвчин гарсантай холбогдуулан сумын онцгой комиссын хурлыг 15 удаа хуралдуулж, цаг үеийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Аймгийн Онцгой комисс, Хүнс, хөдөө аж ахуйн газраас өгсөн заавар, зөвлөмжийн дагуу сумын Засаг даргын захирамжаар хорио цээрийн дэглэмийн тогтоож, хөдөлгөөнт постыг ажиллуулан 2 малчин айлыг тусгаарлах, хүн малыг оруулахгүй байх арга хэмжээ авсан. Үүний дагуу 2017 оны 1-р сарын 1-ний өдөр аймгийн ХХАА-н газрын дарга, МХГ-ын дарга, аймгийн мал эмнэлгийн дарга, аймгийн ОБГ-ын хяналтын байцаагч, МХГ-ын байцаагчид газар дээр нь ажиллаж малчин өрхүүдэд анхааруулга санамж, зөвлөмж өгч өвчилсөн хонийг устгалд оруулах арга хэмжээ авснаас гадна 90 суурьт байгаа 12256 хонинд вакцинжуулалт хийсэн.

Сумын хэмжээнд цас ихээр унаж өвөлжилт хүндрэх төлөвтэй байгаа бөгөөд малчдын өвс, тэжээлийн нөөц багассан тул ойролцоох сумд, Дархан уул аймгаас өвс тэжээл татан авч нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Сүхбаатар сум:

Улс орон даяар зохион байгуулагдаж буй цэргийн үүрэгтэн, бэлтгэл офицеруудын 2017 оны тоо бүртгэлийг зохион байгуулж, бүртгэлд сумын дүнгээр 98,5 хувийн гүйцэтгэлтэй хамрагдлаа.

Стандартын шаардлага хангаагүй архи, согтууруулах ундаа хэрэглэснээс Улаанбаатар хотод хүний амь нас хохирсонтой холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар энэ сарын 17-19-ны өдрүүдэд согтууруулах ундаа худалдахыг хориглосон. Энэхүү захирамжийн хэрэгжилт болон тусгай зөвшөөрлийн тухай, онцгой албан татварын тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжуудын хэрэгжилтийн байдалд холбогдох агентлагуудаас хяналт шалгалт хийгдсэн. Мөн сар шинийн баяр болох гэж байгаатай холбогдуулан ил задгай, гар дээрээс мах, махан бүтээгдэхүүн худалдаалж байгаа байдалд хяналт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд цас цэвэрлэх ажлыг төр төсвийн болон хувийн хэшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийг хамруулах зураглалыг гарган хүргүүлж, зохион байгуулсан бөгөөд цэвэрлэгээнд 120 гаруй аж ахуйн нэгжийн 900 гаруй ажилтан албан хаагчид ажиллаж, 6744 метр замын цасыг арилгасан.

Түшиг сум

Сумын мал, тэжээвэр, амьтад, хашаа худгийн 2016 оны жилийн эцсийн тооллогын ажлыг зохион байгуулж, сумын дүнгээр 50423 толгой мал, 1739 иргэн тоологдсон. Өвөлжилт хүндэрсэн малчин өрхүүдэд туслах ажлыг зохион байгуулж 19 малчин өрхөд Дэлхийн зөн, Улаан хавирган сар нийгэмлэгээс тусламж үзүүлж, 1 иргэнийг гэр оронтой болгосон.

Монгол Улын Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ойн арга хэмжээний хүрээнд төр, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд үндсэн хууль сурталчлах ажлыг зохион байгуулж, ЕБС-ийн сурагчдын дунд АХА тэмцээн, шатрын тэмцээнийг явуулсан.

Улс орон даяар явагдсан 2017 оны цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг явуулж, 87,5 хувь нь хамрагдаж дүн мэдээг аймгийн Цэргийн штабт хүлээлгэн өгсөн.

Мөн архинд хүн хордсонтой холбогдуулан аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдахыг хориглосон аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавин ажиллалаа.

Шаамар сум:

Шаамар сум нь 2016 оны орлогын төлөвлөгөөгөө 131.1 хувиар давуулан биелүүлж, Төсвийн тухай хуулийн дагуу давсан орлогоос цагдаагийн хэсгийг унаажуулах шийдвэрийг сумын ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж суудлын автомашинтай болгосноор нийгмийн хэв журмыг сахиулах, иргэдийн аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлж, цагдаагийн байгууллагын шуурхай байдлыг хангах талаар бодит арга хэмжээ авч ажиллаа.

2017 оны Цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг иргэдэд урсдаг мэдээллийн самбарт байршуулж тусгай хүснэгтийн дагуу хугацаанд нь тоо бүртгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ.

Сумын хэмжээнд 2016 оны мал тэжээвэр амьтдын тооллогоор 23836 толгой мал тоологдож өвөлжиж байна. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан 1, 2 дугаар багийн алслагдмал хэсэгт өвөлжиж буй малчин өрхүүдэд сэтгэлийн дэм үзүүлэх зорилгоор сумын “Өсөх эрдэнэ” бүлгийн хамт олон 10 боодол шүдэнз, 10 хос бээлий, 10 ширхэг малын элгэвч, 4 ширхэг нэмнээ хандивлаж дэмжлэг тусламж үзүүлснээс гадна малчин мал бүхий иргэдэд мал эмнэлэгийн эмч нар хонь, ямааны цэцэг өвчний тандалтыг 241 өрхийн 12586 толгой малд үзлэг хийж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлагаар хангаж, сумын хэмжээнд нийт хонь, ямааны 78 хувийг урьдчилан сэргийлэх вакцинд хамруулж ажиллалаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР